

Дотоод хэргийн их сургуулийн захирлын 2025 оны 10 дүгээр сарын 01-ны өдрийн 11:00-дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ +2740 1119283229

Сэдэв: "Хууль сахиулах ажиллагаа ба хүүхдийн эрхийн асуудал, шийдэл"

Зорилго: Хүүхдийн эрхийг хангах, хамгаалахтай холбоотой олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, хууль сахиулах байгууллагуудын үүрэг, оролцоо, үйл ажиллагааны эрх зүйн болон практик асуудлыг харьцуулан судалж, урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх арга зам, чиг хандлагыг тодорхойлоход оршино.

Зохион байгуулагч:

- Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төв
- Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн сан
- Кристина Ноблийн Хүүхдийн сан
- Канад сан

Хамрах хүрээ: Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, иргэний нийгмийн байгууллага болон их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн, багш, судлаачид.

Хурал зохион байгуулах хэлбэр: Танхим болон цахимаар

Явагдах газар: Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн сан (UNICEF MONGOLIA)-ийн хурлын танхим

Хурал зохион байгуулах хугацаа: 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 10:00-16:00 цаг

Илтгэлд тавигдах шаардлага:

- А.Хэлбэрийн хувьд:
- Сэдэв, илтгэгчийн овог, нэр, эрдмийн зэрэг цол, эрхэлж буй ажил, харилцах утас, цахим хаягийг бичих англи хэлээр орчуулсан байна);
 - Хураангуй (200–250 үтгэй англи, монгол хэлээр);
 - Хураангуй, оршил, судалгааны арга зүй, аргачлал, судалгааны ажлын үр дүн, дүгнэлт, санал, ном зүйгээс бүрдэнэ.

Б.Агуулгын хувьд:

- Судалгааны сэдэв нь хүүхдийн эрх ба хууль сахиулах ажиллагааны уялдаа холбоонд нийцсэн байх;
- Асуудлыг онол, практикийн үндэслэлтэйгээр шинжлэх, үр дүнг бодит баримтаар нотлох;

- Шинэлэг санаа, практик ач холбогдлыг тодорхойлон гаргах;
 - Санал, дүгнэлт нь оновчтой, практикт нэвтрүүлэх боломжтой байх;
 - Зохиогчийн эрхийн зөрчилгүй байх;
- В.Техникийн хувьд:
- 297*210 мм (A4) хэмжээтэй, 8–15 хуудастай;
 - Microsoft Office Word, Arial, 12 pt, мөр хоорондын зай 1.15;
 - Эшлэл, ном зүйг APA форматаар бичих;
 - Хүснэгт, зураг, графикийг дарааллаар дугаарлаж, шаардлагад нийцүүлэх.

Цагийн зохион байгуулалт:

- Илтгэл хэлэлцүүлэх хугацаа: 15минут;
- Асуулт, хариулт: 5 минут байна.

Хурлын зохион байгуулалт:

- Эрдэм шинжилгээний хурал нь үндсэн хуралдаан, бодлогын хэлэлцүүлэгээс бүрдэнэ.
- Эрдэм шинжилгээний хурлаас эмхэтгэлийг эрхлэн гаргаж, нийтийн хүртээл болгох бөгөөд илтгэл хэлэлцүүлсэн, эрдэмтэн судлаачдад батламж, мөнгөн урамшуулал олгоно.

Илтгэл хүлээн авах хугацаа:

- 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 15:00 цаг хүртэл доорх хаягаар хүлээн авна.
- Хэлэлцүүлэхээр шалгарсан илтгэлийг 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр мэдэгдэнэ.
- Цахим хаяг: bayarjargalotgonbayar@gmail.com, onontuul@cncf.mn
- Холбоо барих утас: 99005454, 96040792, 94007893

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ